



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.05.12 № 09/1296

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын шийдвэрийг хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2025 оны санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 116,036.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 28,457.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 33,670.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 53,907.9 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг өгч, мөн санхүүгийн тайлангийн аудитаар хийсэн нийцлийн аудитаар 63,490.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 40,384.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 23,105.4 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг тус тус өгч, танайд хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний аудитын газарт ирүүлж, биелэлтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хугацаанд нь биелүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж тус тус заасныг анхаарч ажиллахыг хүсье.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт 9 хуудастай.

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

  
Д БАЯРСАЙХАН

Z:\Yawsan\_Bchig\2026\0511 SAG-3 Docx

1526141655

## АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба  
Тайланг хугацаа: 2025 он

№	АГАДУТ	Алдаа зөрчлийн тооч утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын	
								Албан тушаал	Өвөг нэр
1	Цалингийн зардалтай холбоотой	Тайланг онд албаны дарга албан хаагчдын албан тушаалын ангилал зэрэглэл, цалингийн шатлал тодорхой бус байхад тушаал гаргаж үндсэн цалинг 2 удаа 15.0-51.2 хувиар нэмэгдүүлж олгосон. Үүнд: 1. Албаны даргын 2025 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн Б/04 дугаар тушаалаар үндсэн цалинг 44.2-51.2 хувиар буюу 651.3 – 1,579.3 мянган төгрөгөөр; 2. Албаны даргын 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар үндсэн цалинг дахин 15.0-20.0 хувь буюу 392.0 – 932.7 мянган төгрөгөөр тус тус нэмсэн.		Албан шаардлага	ЗТС-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/298 дугаар тушаалаар баталсан АХОЗШША-ны дүрмийн Албан удирдлага 4 дүгээр бүлгийн 4.4.6-д заасны дагуу хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулж батлуулах гэж заасан. Тус хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар бүлгийн 7.1 дүгээр заалтад байгууллагын дарга цалингийн сүлжээг тушаалаар батална гэж заасны дагуу цалингийн сүлжээг баталж 2025 оны баталсан төсвийн хүрээнд зохион зарцуулсан.	Албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн хэмжээг холбогдох хууль тогтоомж эрх зүйн актад үндэслэн үнэн зөв тогтоогоогүй, тооцож олгоогүй зөрчлийг таслан зогсоох.	Албан шаардлага		
2	Цалингийн зардалтай холбоотой	Албаны дарга өөртөө тушаал гаргаж үндсэн цалингаа 3 дугаар сард 58.2 хувиар буюу 1,854.2 мянган төгрөгөөр, 7 дугаар сард 26.0 хувиар буюу 1,308.0 мянган төгрөгөөр тус тус нэмж, удаан жилийн нэмэгдлийг үндсэн цалингаас 30 хувиар тооцож, нийт 28,457.5 мянган төгрөг тооцож авсан.	28,457,487.50	Төлбөрийн акт	ИНД61, ИНД65, ИНД66 гэрчилгээ эзэмшигчийн цалинг дүйцүүлж цалингийн сангийн хүрээнд нэмсэн. Цалингийн төсөв хэтрээгүй.	Илүү тооцож авсан 28,457,487.00 төгрөгийн цалинг төлүүлэх.	Төлбөрийн акт		
3	Цалингийн зардалтай холбоотой	Албаны дарга Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас 2026 онд хийгдэх аудитын шалгалтад хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг байгуулж, гишүүдэд 33,670.7 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна. Үүнд: 1.Албаны даргын 2025 оны А/08 дугаар тушаалаар 5 гишүүнийг томилж, 22,354.3 мянган төгрөг; 2.Албаны даргын 2025 оны А/20 дугаар тушаалаар 2 гишүүнийг нэмж томилж, нийт 11,316.4 мянган төгрөгийг тус тус олгожээ.	33,670,659.82	Албан шаардлага	УИХ-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 54 дүгээр тогтоолын 8 дугаар заалтад АНУ-тай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх, үүнд шаардагдах нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн мөлд зарцуулах гэж заасныг мөрдөж ажилласан.	Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон ажлын хэсэг байгуулах, Ажлын хэсгийн гишүүдэд нэмэгдэл хөлс олгодог зөрчлийг таслан зогсоох.	Албан шаардлага		
4	Зардалтай холбоотой	Тээврийн хэрэгсэл ашиглалттай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: - Албан хэрэгцээнд тээврийн хэрэгсэл ашиглах гэрээгүйгээр Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-нд жолоочийн цалинд 34,919.9 мянган төгрөг, шатахуунд 7,573.7 мянган төгрөг, нийт 42,493.6 мянган төгрөгийг шилжүүлсэн; - Шатахуун зарцуулалтын тооцрог автомашины 100 км гүйлтэд зарцуулах нийжэ нормыг баримталж тооцоогүй, авто тээврийн хэрэгслийн урсгал засварын зардалд 10,088.0 мянган төгрөгийн засварыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүнэлттэй хийсэн, авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэр хөтлөөгүй.	52,581,590.54	Зөвлөмж	ИНУТ-тай 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу жолоочийн цалин, шатахууны төлбөрийг шилжүүлсэн. - Шатахуун зарцуулалтын тооцрог ИНУТ-ийн даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/218, ИНУТ-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/612 дугаар тушаалын дагуу бодсон тооцоогоор тооцож, бодсон. - ТӨБЭГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 621 дүгээр тогтоолоор элэгдлээрээ бүрэн нэхсэн Toyota Prado 150, 13-76 УБК улсын дугаартай тээврийн хэрэгслийг ЗьЯ-наас 12 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан. Хүлээлгэн өгсөн актад дурдсан шаардлага хангахгүй байгаа эд ангиыг засуулж хэвийн ажиллагаатай болсон. Тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтөлсөн байгаа.	Барив, ажил, үйлчилгээг холбогдох гэрээ, баримт материалыг үндэслэн санхүүжүүлэх. Жолоочтой шатахуун зарцуулалтын тооцро хийж, автомашины засвар үйлчилгээг өмч хамгаалах комиссын дүнэлтийг үндэслэн хийж, Автомашины техник ашиглалтын дэвтэр хөтлөх.	Зөвлөмж		
5	Барив материалын данстай холбоотой	Цаг бүртгэлийн төхөөрөмж, ай пэдны гэр 603.9 мянган төгрөгийн барив материалыг шууд зардалд бүртгэсэн.	603,900.00	Зөвлөмж	Цаг бүртгэлийн төхөөрөмж, ай пэдны гэрийг барив материалын авлагын дансаар дамжуулж БҮТЗЗ-ээр бүртгэн карт хөтөлж олгож, зардлаар хүлээн зөвшөөрсөн.	Барив материалыг шууд зардлаар бүртгэхгүй байх. Эд хариуцагчийн карт хөтлөх.	Зөвлөмж		
6	Санхүүгийн тайлагналтай холбоотой	Санхүүгийн тайлагналтай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: - Санхүүгийн байдлын тайлангийн эдийн өмчийн дүн 724.8 мянган төгрөг, улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх хөрөнгийн хэмжээ 724,861.4 мянган төгрөг бөгөөд 724,136.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн; - Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 722.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;	722,361.40	Зөвлөмж	Албаны гэрчилгээ нь 2013 онд авахдаа тухайн үед ИНЕГ-аас эзэмшиж байсан хөрөнгийн дүнгээр гэрчилгээний өмчийн дүнг тавиулсан. 2025 оны жилийн хуцаарч ИНЕГ-аас балансаас баланст дээрх хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр шилжүүлж авсан. Гэрчилгээний дүнг засуулах арга хэмжээг авна.	Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх.	Зөвлөмж		

№	АГАДУТ	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагач байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагач байгууллагын	
								Албан тушаал	Овог нэр
7	Санхүүгийн тайлангалтай холбоотой	Тайланг оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанаас хоцроож, УАГ-т 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн.	-	Зөвлөмж	Санхүүгийн тайланг 2026 оны 1 дүгээр сарын 28-ны 13 тоот албан бичгээр Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэн хүргүүлсэн.	Санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх хэсэгт заасан хугацаанд ирүүлэх.	Зөвлөмж		
<b>Санхүүгийн тайлангийн аудитын алдаа, зөрчлийн дүн</b>			<b>116,035,999.26</b>						
1	Төсөвтэй холбоотой	Агаарын хөлийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нь Төрийн байгууллага, албан газар бөгөөд төсвийг Зам, тээврийн сайдын тушаалаар баталж, Иргэний нисэхийн ерөнхий газрын агаарын навигацийн орлогоос санхүүжүүлсэн.	-	Зөвлөмж	Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/298 дугаар тушаалаар баталсан албаны дүрийн 7.1-д заасны дагуу санхүүжилтийг авсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг мөрдөж ажиллах.	Зөвлөмж		
2	Цалинтай холбоотой	ЗТС-ын 2024 оны А/298 дугаар тушаалаар тус албаны зохион байгуулалтын бүтэц, орон тосны дээд хягаарыг баталсан. Тус албаны албан хаагчдын цалинг төрийн албаны цалигийн хэмжээг баримтлаагүйгээр хөдөлмөрийн хөлсний суурь жишгээр тогтоож, олгосон.	-	Зөвлөмж	ЗТС-ын 2025 оны 9 дугаар сарын 24-ний А/241 дүгээр тушаалаар баталсан төсвийн хүрээнд Иргэний нисэхийн салбарын ажилчдын жишиг цалинд дахуулан цалигийн сүлжлийг баталж, захиран зарцуулж ажилласан.	Байгууллага нь Төрийн байгууллага албан газар тул албан хаагчдын цалинг хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож, олгох.	Зөвлөмж		
3	Зардалтай холбоотой	Дотоод томилолтын зардлыг томилолтын тушаалгүй, төсвийг батлуулаагүйгээр олгосон.	-	Зөвлөмж	Шинжлэн шалгах ажиллагааны баг тэмцлэн тушаалын хүрээнд томилолтын зардлыг олгосон.	Томилолтын зардлыг төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг үндэслэж олгох.	Зөвлөмж		
4	Худалдан авах ажиллагаатай холбоотой	Нийт 40,384.8 мянган төгрөгийн компьютер, тэнэг төхөөрөмжийг шууд худалдан авсан бөгөөд тус барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй.	40,384,790.00	Албан шаардлага	Албаны ажилчдын хэрэглэж буй компьютерүүд 2010, 2011 оноос хойш шинэчлэл хийгээгүй хоцрогдсон. ИКАО-гийн шалгалтын хүрээнд хийж ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагаар суурин компьютер, ухаалаг самбарыг багц болгон БСБ дэлгүүрэтэй гэрээ хийж худалдан авсан. Худалдан авалт хийхээс өмнө ЗТС, ТӨБЗГ-т мэдэгдэж худалдан авалтыг хийсэн.	Бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан, барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлээгүй зөрчлийг таслан зогсоох, ТӨОНӨХБААХАТХ-ийг мөрдөж ажиллах.	Албан шаардлага		
5	Шилэн данстай холбоотой	Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд нийт 1,158,120.0 мянган төгрөгийн 38 мэдээ, гүйлгээ мэдээлэхээс 23,105.4 мянган төгрөгийн 6 мэдээ, гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн.	23,105,420.00	Зөвлөмж	Шилэн дансны мэдээллийг тухай бүрд нь мэдээлж байна.	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.	Зөвлөмж		
<b>Нийцлийн аудитын зөрчлийн нийт дүн</b>			<b>63,490,216.00</b>						
<b>БҮГД ДҮН</b>			<b>179,526,209.26</b>						

**Бэлтгэсэн:**

Ахлах аудитор

Ц.Энжаргал

Огноо: 2026.05.07

Хянасан:

Аудитын менежер:

Д.Энхдалай

Огноо: 2026.05.07

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,

Тэргүүлэх аудитор

Д.Баярсайхан

Огноо: 2026.05.07

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

АХОЗШША-ны санхүү, нягтлан бодогч Х.Баярмаа

Холбоо барих утас: 71285090

Цахим шуудан: bayarmaa@aaib.gov.mn